

## ТӨВ АЙМГИЙН 2023 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2023 оны 5 сарын 04-ны өдөр

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2023 оны 04 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **НЭГ. АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн ИТХ, Ажлын албанаас 2023 оны 04 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Аймгийн ИТХ-ын ээлжит бус-4 дүгээр хуралдаанаар 7 асуудал хэлэлцэн, “Ахуйн зориулалтаар агнах, барих агнуурын амьтны тоо хэмжээний хуваарь батлах тухай” 01 дүгээр тогтоол, “Алдарт эх”-ийн одонгоор шагнуулах тухай 02, “Зарим тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай” 03, “Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс өгсөн хандив, тусламжийн хөрөнгийг төвлөрүүлэх, хуваарилах, тайлагнах журам батлах тухай” 04, Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмших тухай асуудлын “Санал өгөх тухай” 05, 06 дугаар, Ашигт малтмал, газрын тосны газраас аймгийн 25 сумын 206 байршилд хайгуулын тусгай зөвшөөрлийн санал ирүүлэх тухай “Санал өгөх тухай” 07 дугаар, 3 сумдад ИТХ-ын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан “Аймгийн Сонгуулийн хороо байгуулах тухай” 08 дугаар тогтоолуудыг батлан гаргалаа.

Сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Ажлын албаны мэргэжилтэнүүдэд 2023.04.17-ны өдөр сургалт семинар хийж -Сумдын ИТХ-ын 2022 оны ажлын үр дүн, анхаарах асуудал, аймгийн ИТХ-аас 2023 онд дэвшүүлсэн зорилт, анхаарах асуудал, Албан хэрэг хөтлөлтийн стандарт, Төрийн албаны тухай хуулийн өөрчлөлт, шинэчлэлт, “Khural.mn” цахим хуудсанд мэдээлэл оруулах, ашиглалт, Сарын ажлын тайлан мэдээ, хариутай бичгийн шийдвэрлэлт, цаашид анхаарах асуудал, Шилэн дансны хөтлөлтөд хяналт тавих тухай, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 2022 оны ажлын үр дүн, 2023 онд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа сэдвүүдээр Аймгийн ИТХ-ын Ажлын албаны холбогдох албан хаагчид мэдээлэл хийж зөвлөмж, чиглэл өглөө.

### **Аймгийн Сонгуулийн хорооны үйл ажиллагааны хүрээнд:**

Аймгийн ИТХ-ын ээлжит бус -4 дүгээр хуралдааны 08 дугаар тогтоолоор байгуулагдсан Бүрэн, Өндөрширээт, Заамар сумдад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгууль зохион байгуулахтай холбогдуулан сумдын сонгуулийн хороог мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах аймгийн Сонгуулийн хороо 04-р сарын 05-ны өдөр анхны хуралдаанаа хийлээ.

Аймгийн Сонгуулийн хорооноос Бүрэн, Өндөрширээт, Заамар сумдын нөхөн сонгуультай холбоотой цаг үеийн ажил мэдээллийг тухай бүр Сонгуулийн Ерөнхий хороонд хүргүүлж ажиллаж байгаагаас гадна тус сумдын Сонгуулийн Хорооны дарга нарт сонгуулийн хорооны тамга, хэсгийн хорооны тэмдэг дардасыг хүлээлгэн өглөө.

Сонгуулийн Ерөнхий хороо, НҮБХХөтөлбөрийн “Жендерийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих” төслийн хүрээнд залуу сонгогчдод сонгуулийн талаарх мэдлэг боловсрол олгох “Хариуцлагатай сонгогч-2023” сургалтыг Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулав.

### **Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн ажлын хүрээнд:**

Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл хамтран “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зөрчилд өсвөр насны хүүхэд залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх “Анзаар” аяныг зохион байгууллаа.

Аяны хүрээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, өсвөр насны хүүхэд залуучуудыг хорт зуршлаас ангид байлгах” сэдвээр сургалт, мэдээллийг сумдад бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж, 04-р сарын 18-нд Зуунмод суманд 1500 гаруй хүн хамруулав.

#АНЗААР аяны арга хэмжээг Төв аймгийн Баянчандмань суманд 04-р сарын 19-ны өдөр зохион байгуулж, төр, хувийн хэвшлийн байгууллагын ажилтан, албан хаагчид, ЕБС-ийн багш,

эцэг эхчүүдийн төлөөлөл, коллежийн оюутан нийт 170 гаруй иргэн танхимаар, 26 сумын ИТХ, ГХУССЗөвлөл, төрийн байгууллага, цагдаагийн алба хаагчид, МСҮТ-ийн оюутан, хорих 417-р анги нийт 768 иргэн цахимаар холбогдож оролцлоо.

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран 27 сумын ИТХ-ын ГХУСАЗСЗ, Хамтарсан багийн нийт гишүүдийг чадавхжуулах сургалтад хамруулахаар төлөвлөж байна.

2023.04.24-нд Батсүмбэр суманд Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр сумдын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах бүсчилсэн сургалтыг хийж нийт 57 албан хаагчийг хамруулан зохион байгууллаа. Сургалтаар Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, хамтарсан багийн гишүүдэд кейс менежмент хийх үе шат, кейс файл бүрдүүлэх, гишүүдийн ур чадварыг сайжруулах, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой бөгөөд.

2023.04.25-нд Баянцогт суманд 4-р ээлжийн Заамар, Угтаалцайдам, Цээл сумдын нийт 57 албан хаагчийг хамруулсан сургалтыг хийв. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах сургалтад Хүүхэд хамгааллын зөвлөл, Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн төлөө “Галт шувуу холбоо” ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Дуламсүрэн “Кейс менежмент” сэдвээр багц сургалт хийв.

Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 27 сумын хамтарсан багийн 300 гаруй гишүүдийг чадавхжуулах сургалтад бүрэн хамрууллаа.

### **ХОЁР. ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хурлыг 4 сард 1 удаа зохион байгуулж, 7 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхай зөвлөгөөнийг оны эхэнд батлагдсан хуваарийн дагуу 04 дугаар сарын 10-ны өдрүүдэд танхимаар зохион байгууллаа.

“Иргэдтэй уулзах цаг” арга хэмжээг 2023 онд зохион байгуулах хуваарийн дагуу 04 дүгээр сарын 05-ны өдөр аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, Цээл, Жаргалант сумдад аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа нар оролцож, 25 иргэний 63 санал, хүсэлтийг хүлээн авч, шийдвэрлэж байна.

Аймаг, сумын хэмжээнд төрийн одон медальд тодорхойлогдсон 121 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Ерөнхийлөгчийн тамгын газарт уламжлав.

2023.04.13-нд Монгол Улсын ЗГХЭГ, Швейцарын хөгжлийн агентлаг хамтран хэрэгжүүлж буй “Төвлөрлийг сааруулах бодлогыг дэмжих төсөл”, “НӨУБ-ын институцийн чадавхийг бэхжүүлэх нь төсөл”-ийн хүрээнд “Нутгийн удирдлагын байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах” сургалтыг аймгийн ИТХ-ын Ажлын алба, ЗДТГ хамтран 27 сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Ажлын албаны мэргэжилтэн, Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль эрх зүйн мэргэжилтэнүүдийг оролцуулан зохион байгууллаа.

2023.04.13-ны өдөр 27 сумын ЗДТГ-ын дарга, Хууль эрх зүйн ажилтны нэгдсэн сургалт семинарыг зохион байгуулж, аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд, төрийн албаны салбар зөвлөл 2023 онд анхаарч ажиллах асуудлаар үүрэг чиглэл өгөв.

Төв аймгийн ИТХ, ЗДТГ, аймгийн Морин спорт, уяачдын холбоо, аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хурдан морины салбар хорооноос Төрийн хишиг хүртсэн улсын цолтой уяачдын “Төв түмний хүлэгч” уулзалт, зөвлөгөөн зохион байгуулж, Төрийн цолтой уяачдад хүндэтгэл үзүүлэн, 100 жилийн ойн хурдан морины уралдааны бэлтгэл, зохион байгуулалтын талаар санал солилцов.

Хотоос хөдөө рүү чиглэсэн шилжилт хөдөлгөөний талаар болон шилжин суурьшигдын талаар цогц ойлголт өгөх Нээлттэй аймаг цахим сайтанд 5 бүлэг асуудлаар 468 мэдээллийг нэгтгэн оруулж нийтэд нээлттэй танилцуулав.

Монгол Улсын Засгийн газраас батлан хэрэгжүүлж буй “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, түүний эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ын уялдаа холбоо, зорилго зорилтыг төрийн албан хаагчдад сурталчлан таниулах, хэрэгжүүлэх, үр дүнг нь үнэлэх сертификатын сургалтанд хамрагдсан 300 сургагч багш нар сум байгууллагадаа Алсын хараа-2050 сургалтыг нийт 2100 төрийн албан хаагч, иргэнд зохион байгуулж, цахим сургалтын агуулгыг судлуудан шалгалтыг өгүүлж, сертифициат олгуулах ажлыг зохион байгуулж байна.

ЗГХЭГ-аас өгсөн үүрэг чиглэлийн дагуу 2023 оныг Авлигатай тэмцэх жил болгосонтой холбогдуудан зохион байгуулж байгаа “Шүүр” ажиллагааг хэрэгжүүлэх удирдамжийн дагуу 3 ажлын хэсэг томилон 27 сумд, төрийн байгууллагуудад тусгай удирдамжаар шалгалт хийж,

тайлан мэдээллийг нэгтгэн илэрсэн зөрчил дутагдлыг арилцуулах талаар сум байгууллагуудын удирдлагуудад үүрэг чиглэл өгөв.

2023 оны 3 дугаар сарын 13-17-ны өдрүүдэд Япон Улсын Тоттори мужийн Захиргаанаас жил бүр зохион байгуулдаг Төрийн албан хаагчдын солилцооны хөтөлбөрт аймгийн ЗДТГ-ын ХШҮХ-ийн дарга Т.Хуягбаатар, СТСХ-ийн мэргэжилтэн Н.Хорлоо нар хамрагдлаа.

2023 оны 3-р сарын 9-ний өдөр БНСУ-ын Пёнтек хотын Захирагчийн урилгаар аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар болон бусад албаны хүмүүс Пёнтек хотын захирагч ноён Жон Жан Сон болон тус хотын ИТХ-ын дарга нартай уулзлаа. 2023 оны 4-р сарын 5-ны өдөр БНСУ-ын Кангвон мужийн Захирагч Ким Жин Тэ-н урилгаар аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн ИТХ-ыг дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-ийн дарга Б.Ганхуяг нар Кангвон мужид албаны айлчлал хийж уулзалт зохион байгууллаа.

2023 оны 4-р сарын 19-ний өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хинган аймгийн гадаад харилцааны газартай аймгийн ЗДТГ-ын дарга М.Отгонбат, ТЗУХ-ийн дарга С.Магнайбаяр нар цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцон цахим хурал зохион байгууллаа.

Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн бэлтгэл ажлын хүрээнд “Төв 100” пэйж хуудсыг нээн ажилуулж байна. Тус пэйжид тайлант хугацаанд 109 төрлийн мэдээлэл орж, давхардсан тоогоор 19200 гаруй хандалт аваад байна. Аймгийн 100 жилийн ойн логог нийгмийн сүлжээгээр түгээх ажлыг зохион байгуулж байна.

“Төв сайхан нутаг-100” хүндэтгэлийн тоглолтын шторкыг аймгийн 2ТВ, төвийн гэрээт 4 ТВ-гээр нэвтрүүллээ. Мөн тоглолтын үеэр ТВ5, Өлзий, MNB ТВ болон zugii.mn сайтаар мэдээ бэлтгэн нэвтрүүлсэн. Тоглолтыг TBS, ТӨВ ТВ-тэй хамтран бүтэн бичлэг хийсэн. Аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээс “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн 3 дугаарыг бэлтгэн түгээлээ. Төв аймаг/tuv province пэйж хуудсаар дамжуулан 27 сумын танилцуулга, Хэн юу хэдэв цуврал фостер, Төв аймагчууд түүхийн хуудаснаа цуврал материалыг түгээн ажиллаж байна.

Төв ТВ, ХХААГ-тай хамтран “Төв түмний аваргууд” нэвтрүүлгийн 16 дугаар хийсэн. Мөн Төв аймгаас төрөн гарсан алдар гавъяатнуудын талаар нэвтрүүлгийн зураг авалтыг хийгээд байна. TBS телевизтэй хамтран “Төв нутгийн 100 жилийн түүхэн замнал” нэвтрүүлгийн 23 дугаарыг бэлтгэн нэвтрүүлээд байна.

### **ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВИЙН ХҮРЭЭНД:**

Аймгийн Үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт **16** байгууллага **600-аад** төрлийн үйлчилгээг **6372** иргэнд, өдөрт дунджаар **250-300** иргэнд хүргэн үйлчилжээ.

Цахим үйлчилгээний нэгдсэн систем /www.e-mongolia.mn/-ээр дамжуулан аймгийн хэмжээнд **986** лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ҮНТөвийн операторуудаас **520** лавлагаа үйлчилгээ авсан байна. Мөн E-Mongolia үйлчилгээний тухай заавар зөвлөмжийг, төрийн үйлчилгээг цахимаар авч болох тухай мэдээ мэдээллийг **150** иргэнд хүргэж ажилласан байна.

Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд **8** гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжилсан.

Өөрөө өөртөө үйлчлэх цахим мэдээллийн буланд иргэд өөртөө үйлчлэх зориулалт бүхий газрын албаны киоск машин, төлбөр төлөлтийн “Гэрэгэ” киоск машинуудыг байршуулсан. Мөн Цахим үйлчилгээний нэгдсэн систем [www.e-mongolia.mn](http://www.e-mongolia.mn), Газрын мэдээллийн нэгдсэн сангийн [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn), Аймгийн албан ёсны веб сайт [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), Аймгийн статистикийн хэлтсийн [www.nso.gov.mn](http://www.nso.gov.mn) сайтуудыг холбосон 4 ухаалаг дэлгэцийг тус тус байршуулан иргэдэд цаг үеийн болон дотоод ажил үйлчилгээтэй холбоотой мэдээ мэдээллийг тогтмол хүргэж байгаа бөгөөд газрын нэгдсэн систем болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаар дамжуулан нийт **110** иргэн газрын талаарх үйлчилгээ авсан бол Гэрэгэ киоскоор дамжуулан **31** иргэн машины татвар, торгууль, улсын бүртгэлийн лавлагаа, жолоочын хариуцлагын даатгал, үүрэн телефоны нэгж авах зэрэг үйлчилгээнүүдийг авчээ.

Засгийн газрын 2022 оны 499 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болох Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдаж аймаг бүрт 5 хүний бүтэц, орон тоотой Төрийн цахим үйлчилгээний хэлтэс байгуулагдсан. Тус хэлтэс нь иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүйгээр хаанаас ч ойрхон авах боломжийг бүрдүүлж **“ХУР-ДАН”** төвийн нээлт хийсэн.

## ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ХҮРЭЭНД:

Монгол Улсын Шадар Сайдын “Гэр хорооллын айл, өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж” аймгийн Засаг даргын 2023 оны А/61 дүгээр захирамжийн дагуу Баянхангай, Угтаалцайдам, Баянцогт, Аргалант сумдад нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Монгол Улсын Шадар Сайдын 2023.01.09-ний “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-г тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөг гарган төлөвлөгөөний дагуу нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан.

Аймгийн Онцгой байдлын газрын даргын баталсан гамшгаас хамгаалах, галын аюулгүй аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээ”-ийн дагуу Гамшгаас хамгаалах болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2023.04.04-25-нд зохион байгуулан ажиллалаа.

Онцгой байдлын газрын даргын батлагдсан удирдамжийн хүрээнд Төв аймгийн Зуунмод сумын хэмжээнд “Төр захиргааны болон авто засвар үйлчилгээ, угаалгын газар”-ын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 14 байгууллага хамрагдсанаас гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд хуулийн этгээдийн үүргийн хэрэгжилтийн зөрчил 42-ыг илрүүлэн газар дээр нь 3 зөрчлийг арилгуулж, улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 14-ийг бичиж хүргүүлсэн.

Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Баянхангай, Угтаалцайдам, Баянцогт, Аргалант сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг Аж ахуй нэгж, байгууллага, барилга байгууламжид төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, галын аюулгүйн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах зорилгоор нийт 26 байгууллага хамруулснаас гал түймэр, ослын аюулд хүргэж болзошгүй 139 зөрчил илэрч, 76 зөрчлийг газар дээр нь арилгуулж, ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлтийн хугацаа дууссан 2 байгууллагын дүгнэлтийг хураасан. Нийт илэрсэн зөрчил дутагдалд заавал биелүүлэх албан шаардлага хүргүүлэхээр төлөвлөв.

2023.04.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан шалгалтад Угтаалцайдам, Баянхангай, Аргалант, Баянцогт сумдын 1061 айл өрх хамрагдсан бөгөөд үзлэг шалгалтаар 3489 зөрчил дутагдал илрүүлж, 2548 зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, 5469 иргэнд галын аюулаас урьдчилан сэргийлэх, цахилгааны хэт ачаалал үүсгэхгүй байх, бага насны хүүхдийг болзошгүй ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх гарын авлага материал 5897 ширхгийг тараан заавар, зөвлөмж өгч галын аюулаас урьдчилан сэргийлэх болон пийшин зуухны аюулгүй байдлыг хангах талаар ухуулга сурталчилгаа хийж дүгнэж ажилласан.

Үзлэг шалгалтаар явах хугацаанд дараах зөрчилүүдийг илрүүллээ. Үүнд:

- Пийшин зуухны өмнө үл шатах тавцан байхгүй -386;
- Яндангийн залгаас буруу -278;
- Пийшин зуухны амны түгжээ байхгүй – 554;
- Гэр хоорондын зай ойрхон – 326;
- Үнс нурмаа ил задгай, таггүй саванд асгасан – 359;
- Цахилгаан утасны холболт ил – 1046;
- Шатах тослох материал хадгалсан -126;
- Ил задгай өвс хураасан – 258;
- Бага насны хүүхэд гэрт нь үлдээсэн – 156 тус тус илэрсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрд урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартаа хамтран ангиллын сургалтыг танхим хэлбэрээр зохион байгуулж, 29 удаагийн 58 цагийн сургалтаар 2747 хүнийг хамрууллаа.

Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн дагуу газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, объектын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, гамшгаас хамгаалах тухай, галын аюулгүй байдлын тухай хууль сэдвүүдээр нийт 22 удаагийн сургалт зохион байгуулж, 1803 хүнийг хамруулсан байна.

Тус сургалтаар Баянхангай, Угтаалцайдам, Баянцогт, Аргалант сумдын ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд, бага ангийн нийт 1046 сурагчдад “Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх”, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын нийт 365 хүүхэд, багачуудад “Аврагч мазаалай” видео хичээлээр аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг олгож, нийт 1026 ширхэг гарын авлага тараасан.

Мөн тус сумдын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 93 багш, ажилчид, сумдын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвийн нийт

299 алба хаагч, иргэдэд танхимын сургалт зохион байгуулж, 702 ширхэг гарын авлага, тараах материалыг тараасан.

Онцгой байдлын газраас зохион байгуулсан гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээ, сургалт, сурталчилгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээнд хамрагдсан айл өрхийн тоо 26,5 хувиар, иргэдийн тоо 15,9 хувиар, сургалт орсон тоо 12,3 хувиар, сургалтад хамрагдсан иргэдийн тоо 25,3 хувиар, иргэдэд тараасан сэрэмжлүүлэх материал, гарын авлагын тоо 18,7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Монгол Улсын Шадар Сайдын 2023 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамжийн хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Үүнд: Шар усны үерийн аюулыг ард иргэд, олон нийтэд таниулах үйл ажиллагааг аймгийн 27 сумын нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гамшгаас хамгаалах мэргэжлийн алба, мэргэжлийн ангийн томилгоот бүлгүүдийн бэлтгэл, бэлэн байдалд хяналт тавих чиглэлээр зохион байгуулах арга хэмжээний талаарх Гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагчийн албан мэдэгдэл, удирдамжийг сумдын Засаг дарга нарт хүргүүлж, 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр үр дүн нэгтгэж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.

Мэргэжлийн байгууллагуудын хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг тухайн шатны Засаг даргын захирамжаар томилж, нийт 16 ажлын хэсэг байгуулагдаж, мэргэжлийн ангийн 1254 бүрэлдэхүүнд тодотгол хийж, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах;

Цаг агаарын урьдчилсан мэдээг орон нутгийн хэмжээнд нарийвчлан тодруулж, шар усны үер, мөс цөмрөхөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээг 5870 иргэд, малчид, “Багц мессеж” хэлбэрээр нийт 133 удаа 1121 иргэнд хүргэх;

Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх, баталгаагүй зам, гарц, гарман дээр анхааруулах сэрэмжлүүлэг самбарыг 10 сумын хэмжээнд нийт 23 ширхгийг байршуулах;

Гол, нуурын арал, тохой, эрэг дагуу болон уулын ам, бэл, гуу, жалга, сувгийн ойролцоо айл өрх, аж ахуй нэгж байгууллагуудыг бууж суурьшихгүй байхыг анхааруулах, эрсдэл бүхий газар нутагласан 147 айл өрхийн судалгааг гаргаж, 9 айлыг эрсдэлтэй бүсээс нүүлгэн шилжүүлэх;

27 сумын хэмжээнд үерийн хамгаалалтын далан, зам, гүүрний ус зайлуулах зориулалтын байгууламжид үзлэг шалгалт хийж, 45 хуулийн этгээдийг цэвэрлэгээнд татан оролцуулж, нийт 88,447м<sup>2</sup> үерийн далан шуудууны хогийг цэвэрлэх;

Нэгдсэн арга хэмжээний хугацаанд сум, баг тус бүр дээр 2-оос доошгүй удаа “Шар усны үерээс урьдчилан сэргийлэх өдөрлөг” зохион байгуулах, нэгдсэн арга хэмжээ болон сэрэмжлүүлэг мэдээг орон нутгийн цахим хуудсанд байршуулж, олон нийтэд хүргэх; зэрэг арга хэмжээг зохион байгуулав.

Онцгой байдлын газрын фейсбүүк болон веб сайтад “Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх” сэрэмжлүүлэг шторк 1, постер мэдээлэл 3 бэлтгэн 27 сумын мэдээллийн нийт 55 сайтад 266 удаагийн давтамжтай байршуулсан 34,110 иргэнд хүргэсэн байна.

Угтаалцайдам, Баянхангай, Аргалант, Баянцогт сумдын сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн 93 багш, ажилчид, сумдын Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төвийн зэрэг нийт 299 алба хаагч, иргэдэд танхимын сургалт зохион байгуулж, 702 ширхэг гарын авлага, тараах материалыг тараан ажилласан зэрэг арга хэмжээг зохион байгуулж ажилласан байна.

Монгол Улсын Шадар Сайдын “Гэр хорооллын айл, өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”, аймгийн Засаг даргын 2023 оны А/61-р захирамжийн хэрэгжилтийг хангах, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх мэдлэг боловсрол олгох, объектын галын аюулгүй байдлыг хангах, гал түймрийн тоо, хохирол, эрсдэлийг бууруулах зорилгоор Баянхангай, Угтаалцайдам, Баянцогт, Аргалант сумдад гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдлыг хангуулах нэгдсэн арга хэмжээг 2023.04.05-07-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Нэгдсэн арга хэмжээний хүрээнд Баянхангай, Угтаалцайдам, Баянцогт, Аргалант сумдад Гамшгаас хамгаалах тухай, Галын аюулгүй байдлын тухай хуулийг дагаж мөрдөх, гэр хорооллын айл, өрхүүдийн пийшин зуухны галын аюулгүй байдлын стандарт норм, нормативыг хэрэгжүүлэхийн ач холбогдол, эрсдэлийг тайлбарлан таниулах, аюулгүй галлагааны заавар зааварчилгааг ухуулан сурталчлах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж заавар зөвлөгөө өгч ажилласан.

Онцгой байдлын газраас сар бүр бэлтгэн хүргэдэг “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийн 2023 оны 04 дүгээр сарын дугаарыг бэлтгэн олон нийтэд хүргэсэн.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 72 удаа хүргэсэн.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэсэн.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 5будаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 12 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 21 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 25 удаа нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангасан.

Онцгой байдлын газраас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 10 төрлийн постер 7 төрлийн видео бичлэгийг байршуулсан.

Ой, хээрийн гал түймэр-2, Объектын гал түймэр-8, Мал, амьтны гоц халдварт өвчин-1, Эрэн хайх, ажиллагаа-2, тэсэрч, дэлбэрэх бодисын осол-1 нийт 14 дуудлага, мэдээлэл хүлээн авч гал түймэр унтраах, эрэн хайх аврах, хор уршиг арилгах үйл ажиллагаанд онцгой байдлын газраас давхардсан тоогоор 40 алба хаагч, 7 техник, эрэлч нохой-1, орон нутгийн иргэд-100, 45 техниктэй аюулт үзэгдэл, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн.

## **ГУРАВ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭНД:**

### **УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Монгол улсын анхдугаар Үндсэн хуулийн 100 жилийн ойг угтан Үндсэн хуулийн үзэл баримтлалыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, Үндсэн хуулийн хэрэглээг нэмэгдүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр “Иргэдийн шударга шүүх” төрийн бус байгууллагатай хамтран аймгийн хэмжээнд “Үндсэн хуулийн дугуйлан төсөл”-ийг хэрэгжүүлж орон нутгийн төсвөөс 27 сая төгрөгийг шийдвэрлэн 27 сумын 2000 гаруй иргэнд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулах өөрчлөлтийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлгийг аймгийн Монгол туургатан театрт зохион байгуулж 270 иргэнийг оролцуулан санал авч ажиллалаа.

Аймгийн Захиргааны хэргийн анхан шатны шүүх болон сумд дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж шүүх хуралд оролцлоо. Аймгийн Засаг даргын 56 захирамж, 2 тушаал 2 гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж зөвлөгөө өглөө.

Аймгийн хэмжээнд Төрийн албаны хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх “Шүүр” ажиллагаа, хүний нөөцийн аудитын зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт шалгалт хийх ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/206 дугаар захирамжаар байгуулан аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа 25 байгууллага, 27 сумын төрийн 169 байгууллага, 4598 албан хаагчийг хамруулан хяналт шалгалт ажлыг зохион байгууллаа. Хяналт шалгалтаар хууль тогтоомж, шаардлагыг зөрчиж томилогдсон 212 томилгоо илэрснийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зөрчлийг арилгууллаа.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2000-2022 онд баталсан захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ хийж ач холбогдлоо алдаж дагаж мөрдөхөө больсон, хууль тогтоомжтой давхардсан зэрэг хүчингүй болгох шаардлагатай 26 тогтоолын хэрэгжилтийг гаргаж аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж хүчингүй болгож, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүллээ.

Аймгийн Засаг даргын 2023 оны А/259 дугаар захирамжаар Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсонтой холбогдуулан тэмдэгтийн хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох захиргааны хэм хэмжээний актын төслийн бэлтгэх боловсруулах ажлын хэсгийг байгуулж бэлтгэл ажлыг хангалаа.

Монгол Улсын Засгийн газрын “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг эрчимжүүлэх чиглэлээр Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран сум, баг, байгууллагад “Эрх зүйн хөтөч” бэлтгэх, давтан сургах, чадавхжуулах сургалт зохион байгуулж 143 албан хаагчийг чадавхжууллаа.

Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн Сүхбаатарын одонт, Байлдааны гавьяаны одонт, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, цагдаагийн тангараг давтах ёслолын арга хэмжээг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаанд Цагдаагийн Ерөнхий газрын удирдлага, Төв аймгийн удирдлагууд, Зуунмод хотын удирдлагууд, Төв аймгийн Цагдаагийн газрын удирдлага, бие бүрэлдэхүүн болон Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын удирдлага, бие бүрэлдэхүүн, цагдаагийн албанд ажиллаж байгаад чөлөөндөө гарсан ахмадууд, иргэдийн төлөөлөл оролцлоо.

Аймгийн Цагдаагийн газар үүсэн байгуулагдсан түүхт 80 жилийн ойг угтаж иргэд, олон нийтэд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчлах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ” арга хэмжээг зохион байгуулж орон нутгийн хууль сахиулах байгууллагууд оролцож нийт 470 иргэнд үйл ажиллагаа сурталчилж, хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллалаа.

Аймгийн Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг дээшлүүлэх албан хаагчдын эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх, хөдөлгөөний хомсдолоос сэргийлэх, сайжруулах зорилгоор хууль сахиулах байгууллагын дунд спортын цогцолбор тэмцээнийг зохион байгуулж 300 гаруй албан хаагч оролцож хамтран ажиллалаа.

Цагдаагийн Ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газар, аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Цагдаагийн газар, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар хамтран “Анзаар” арга хэмжээг аймгийн хэмжээнд хэрэгжүүлж мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг, зөрчилд өсвөр насны хүүхэд залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд олон нийтийн мэдлэг, ойлголт, эрх зүйн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг 53 байгууллага, 1500 гаруй иргэн, төрийн албан хаагчийг хамруулан зохион байгууллаа.

Аймгийн хэмжээнд зам, тээврийн осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр осол, аваар ихээгэрдаг хар цэг болон авто осол гарч болзошгүй газруудыг судлах, шалтгаан нөхцөлийг олж тогтоох, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал, дүгнэлтийг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын 2023 оны а/261 дүгээр захирамжаар байгуулан судалгааны ажил хийгдэж байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс Шүүх, шинжилгээний хэлтсийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж орон нутгийн төсвөөс 20,0 сая төгрөгийн өртөг бүхий экологийн шинжээчийн багаж, техник хэрэгслийг хүлээлгэн өглөө.

Улсын бүртгэлийн хэлтсээс үйл ажиллагааг иргэдэд сурталчлах зорилгоор Цээл суманд “Нээлттэй хаалганы өдөрлөг” зохион байгуулж 129 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өглөө. Өдөрлөгийн үеэр хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг 84 иргэн, хуулийн этгээдэд олгож, төрийн үйлчилгээг шуурхай хүргэж ажиллалаа.

Төв Баянжаргалан, Цээл сумын Засаг даргын Тамгын газрын эрх бүхий 6 албан тушаалтны үйл ажиллагаандаа хэрэглэдэг тамга, тэмдгийг шинэчлэх ажлыг зохион байгууллаа.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагчийн 2023 оны төлөвлөгөөний дагуу аймгийн Музей, Ус цаг уур орчны шинжилгээний төв, Боловсрол шинжлэх ухааны газрын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж зөвлөмж, байцаагчийн албан шаардлага хүргүүллээ.

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга нарт “Албан бичиг зохион бүрдүүлэх арга зүй”, аймгийн Газрын харилцаа хот байгуулалтын газрын албан хаагчдад “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-аар сургалт зохион байгууллаа.

Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар, Эрдэнэ сумын Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн Архив, албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтнуудыг Төв Төрийн Архивт сургалт-дадлагын ажлыг хийлгэлээ.

Төрийн архивын дэргэдэх Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлыг зохион байгуулж 17 байгууллагын байнга, түр бүртгэл, устгах хэргийн жагсаалт, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг хэлэлцэн, шийдвэрлэлээ.

Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, аймгийн Морин спорт, уяачдын холбоо хамтран “Төв түмний хүлэгч” уулзалт, зөвлөгөөнийг зохион байгууллаа. Уулзалт, зөвлөгөөнд Төрийн цолтой

уяачдад хүндэтгэл үзүүлж, 100 жилийн ойн баримтат кино, номны зураг авалт, баяр наадмын хурдан морины уралдааны бэлтгэл зохион байгуулалтын талаар санал солилцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн үйлчилгээ-мэдээллийн төв, Музейтэй хамтран Төв аймаг байгуулагдсаны 100 жилийн түүхэн ойд зориулсан “Үлдээх өв” цуврал контентыг бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.

#### **ТӨРИЙН АРХИВЫН ЧИГЛЭЛЭЭР**

Төрийн архивын эх баримтаас лавлагаа, хуулбар авах хүсэлт ирүүлсэн 128 иргэний хүсэлтийг хүлээн авч 769 хуулбар хувь олгож, 84 лавлагаа, 149 хөмрөгийн 634 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 584,000 төгрөгийг орууллаа.

1 хөмрөгийн 125 хадгаламжийн нэгжийн 2795 хуудас баримтын 2795 заалтын тоо, 2795 тушаалын тоо, 14946 хүний нэрийн мэдээллийг програмд оруулж, 1 хөмрөгийн 2795 заалтыг PDF.JPEG хэлбэрт хувиргаж, 2795 заалтын 2795 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбож цахим бааз үүсгэлээ. Баримтын нөхөн бүрдүүлэлтээр 3 хөмрөгийн 84 төрлийн баримтыг хүлээн авч, хадгаламжийн нэгж болгон бүртгэлээ.

#### **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 66897 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 138775 газар өмчлөх эрхийн 54853 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1768 байна. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 230 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос 24.0 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 84.7 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2.3 төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 2984 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 119 нэмэлт өөрчлөлт, шинээр 67 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 1, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 24 бүртгэл хийгдсэн. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 38 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 79 лавлагаа өгсөн. Хуулийн этгээдийн бүртгэлийн тэмдэгтийн хураамжийн орлого нийт 17.1 төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.

#### **ЦАГДААГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 191 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс 87 хэргээр буюу 31 хувиар буурч, гэмт хэргийн илрүүлэлт 45,9 хувьтай байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд гудамж талбай олон нийтийн газар ухаангүй унасан, ар гэртээ согтуугаар танхайрсан зөрчил гарган эрүүлжүүлэгдсэн-8, шүүхээр баривчлагдсан-51, албадан саатуулсан-9, ар гэрт нь 12 иргэнийг хүлээлгэн өгч, нийт 80 иргэнийг эрүүлжүүлэх саатуулах байранд код журмын дагуу биед эрүүл мэндийн үзлэг хийж, хүлээн авч ажиллалаа.

Нийтийн хэв журам хамгаалах тасгаас нийтийг хамарсан 8 удаагийн хамгаалалтад давхардсан тоогоор 42 алба хаагч, 15 автомашин, 42 тусгай хэрэгсэл, 8 холбооны хэрэгсэл, ашиглаж 185 цагийн үүрэг гүйцэтгэлээ.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд "Архи, согтууруулах ундааны эргэлт", "Электрон тамхины хор нөлөө" зэрэг хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгууллаа.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гудамж замын хяналт шалгалтаар 7103 зөрчил илрүүлж, согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 101 жолоочийг илрүүлэн тээврийн хэрэгслийг түр саатууллаа.

Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 65 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасч, 36 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр 7-30 хоног баривчлуулж, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 74 жолоочийг илрүүлэн Цагдаагийн ерөнхий газрын нэгдсэн санд мэдээллийг бүртгэлээ.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 6928 жолоочийг 168,6 сая төгрөгийн торгууль оногдууллаа.

#### **ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР**

Криминалистикийн шинжилгээ-49, магадлан шинжилгээ-75, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо-159, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-343, гарын хээний санг дардсаар баяжуулсан-88, мөрөөр баяжуулсан-46, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт-220, ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилт-75, гистологийн шинжилгээ-75 хийгдлээ.

#### **ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР**



Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохиx	Бодитой биелүүлсэн	Дундаж хувь
4-р сар	309	204	8	505	142	28,1
	4857937.6	2436892.6	175965.1	7118865.1	1108000.7	

## ДӨРӨВ. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ-ҮНЭЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:

### Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

Төрийн албаны хууль тогтоомж, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх "Шүүр" ажиллагаа, Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "Хүний нөөцийн аудит 2022" зөвлөмж, төрийн албан хаагчийн 2023 оны томилгоотой холбоотой мэдэгдлийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд хэлтэс, агентлаг, харьяа байгууллага болон сумдад ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд сум, баг, байгууллагад "Эрх зүйн хөтөч" бэлтгэх, давтан сургах зорилгоор сумдын Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн мэргэжилтэн нарыг чадавхжуулах сургалтад Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын хүрээнд сургалт зохион байгуулж цаашид анхаарах асуудлын талаарх хэлэлцүүлэг зохион байгууллаа.



### Санхүүгийн хяналт, дотоод аудитын чиглэлээр:

2023 оны 04 дүгээр сарын 25-ны байдлаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад ОНХС, ХХС, ЭЭС-ийн үйл ажиллагаанд дотоод аудит, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, түүний зарцуулалтад санхүүгийн хяналт шалгалт хийж 546,767.3 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 15530.2 мянган төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 537,402.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага өгч ажиллаа.

Санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Төв аймгийн Мэдээлэл сүлжээний газар, Монголын цахилгаан холбооны салбар, Монгол шуудан салбаруудад санхүүгийн хяналт шалгалт хийж 2001.6 мянган төгрөгний зөрчил илрүүлж санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагчийн акт тогтоож ажиллалаа.

Сангийн яамны нэгдсэн удирдамжийн дагуу Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаа болон сангуудын 2021-2022 оны баримтуудад санхүүгийн хяналт шалгалт хийгдэж байна.

Эхний 4 сарын байдлаар: Нийт илрүүлсэн зөрчил- 554,934.6 мянган төгрөг үүнээс

➤ СХШУ-ын ахлах байцаагчийн акт – 17,531.8 мянган төгрөг

➤ СХШУ-ын ахлах байцаагчийн албан шаардлага- 537,402.8 мянган төгрөг

Өмнөх онуудын актын үлдэгдэл 190,473.4 мянган төгрөгийн актын үлдэгдлээс 24546.5 мянган төгрөг барагдаж үлдэгдэл 165926.9 мянган төгрөг байна.

## **ТАВ. САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХҮРЭЭНД:**

### **Төсвийн орлогын талаар:**

Орлогын төлөвлөгөө 2023 оны 04 дүгээр сарын байдлаар орон нутаг 6,833,3 сая төгрөг төвлөрүүлэхээс 8,087,1 сая төгрөг төвлөрүүлж 118,3 хувьтай, 1,253,8 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давсан байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 747,5 сая төгрөг төвлөрүүлэхээс 1052,7 сая төгрөг төвлөрүүлж 140,8 хувьтай, 305,2 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 10,998,0 сая төгрөгөөр биелж, 124,1 хувьтай байна. 3-н шатны орлогын төлөвлөгөөг биелүүлсэн 11 сум байна. Үүнд: Архуст, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Заамар, Өндөрширээт, Цээл, Эрдэнэ, Эрдэнэсант, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Баяндэлгэр, Баянжаргалан, Баян-Өнжүүл, Баянцагаан, Лүн, Мөнгөнморьт, Сүмбэр, Угтаал, Зуунмод зэрэг 9 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баян, Баянхангай, Бүрэн, Дэлгэрхаан, Сэргэлэн зэрэг 7 сум байна. 3 шатны орлогын төлөвлөгөө тасалсан сум байхгүй.

### **Төсвийн зарлага, санхүүжилтийн талаар:**

Аймгийн төсвөөс 2023 оны 03 дугаар сарын байдлаар нийт 13,324,3 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн төсвийн байгууллага болон 27 суманд олгосон.

### **Зарлагыг салбараар авч үзвэл:**

Боловсрол, шинжлэх ухааны байгууллага 3,948,1 сая төгрөг

Эрүүл мэндийн байгууллага 356,5 сая төгрөг

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбар 6,238,3 сая төгрөг

Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагууд 3,676,8 сая төгрөг, нийт 14,219,7 сая төгрөгийн зарлага гаргаад байна.

### **Өр, авлагын талаар:**

2023 оны 03-р сарын байдлаар сумд, болон төсөвт байгууллагууд нийт 311,9 сая төгрөгийн авлага, 364,1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 252,8 сая төгрөг буюу 69,4 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 0,6 сая төгрөг буюу 0.2 хувь нь цалингийн өглөг, 10,7 сая төгрөг буюу 2,9 хувь нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр, 40,9 сая төгрөг буюу 11,3 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 58,9 сая төгрөг буюу 16,2 хувийг бусад өр эзэлж байна

## **ЗУРГАА. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО,ТӨЛӨВЛӨЛТИЙН ХҮРЭЭНД:**

### **БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

**Хот байгуулалтын хүрээнд:** Архитектур төлөвлөлтийн 27 даалгавар боловсруулснаас 9 даалгавар олгож, шинээр барих барилгын зураг төсөл зөвшөөрөлцсөн баталгаажуулах шатанд байршилыг ерөнхий төлөвлөгөөний хүрээнд батлах, орон нутгийн саналыг зурагт тусгах ажлыг хийж гүйцэтгэлээ. 2023 онд 32 зураг төсөл зөвшөөрөлцөж, энэ сард 15 зураг төсөл баталсан байна.Барилга, инженерийн байгууламжийн зураглалыг шалгаж, хот байгуулалтын мэдээллийн санд 10 гүйцэтгэлийн зураг хүлээн авч акт олгож энэ сард 4 гүйцэтгэлийн зураг хүлээн авлаа..

**Барилга захиалагч, хяналтын хүрээнд:** Улсын төсөв, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 33 төсөл арга хэмжээ 61.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил захиалагчийн чиг үүргийг гүйцэтгэн ажиллаж байна. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж 10 ажилд худалдан авах ажиллагааг зарлахаар төлөвлөн 5 ажил гэрээ байгуулах шатандаа, 05 дугаар сарын 01 ний өдөр 2 тендерын төсөл арга хэмжээ нээгдэнэ.

Аймгийн нутгийн удирдлагын ордны өргөтгөл, их засвар, цэнгэлдэх хүрээлэнгийн барилдааны талбайд таримал хуйлмал зүлэг суурилуулах, нийтийн зориулалттай орон сууцны подвалын бохирын шугам сүлжээг шинэчлэх /Зуунмод сумын 19, 20, 21, 22-р байр/ төсөл арга хэмжээ гэрээ байгуулж гүйцэтгэж байна.

Нийтийн зориулалттай орон сууцны барилгын гэрэлтүүлгийн ажил (16, 17, 18, 19, 20, 21, 22, 101, 1, 27, 40, 41, 42, 46, 47, 48, 25, 201, 400, 501, 502, 111), нийтийн орон сууцны төв магистрал шугам сүлжээ шинэчлэх (16, 17, 18-р байр), аймгийн Залуучуудын ордны дээврийн их засвар, Төв цэнгэлдэх хүрээлэнгийн сүүдрэвч, гадна дотор тойрог замыг асфальтаар хучих ажлууд гэрээ байгуулах шатандаа хэрэгжиж байна.

Төв цэнгэлдэх хүрээлэнгийн явган зам талбайн шинэчлэл, нийтийн тээвэр-Зуунмод төсөл хэрэгжүүлэх тендер зарлагдаад байна.

### **ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ ЧИГЛЭЛЭЭР:**

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөлтийн тусгагдсаны дагуу газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдаа Баян-Өнжүүл, Өндөрширээт, Зуунмод, Эрдэнэсант сумын 14 нэгж талбарын дуудлага худалдаа, Зуунмод сум, Сэргэлэн сум 6 нэгж талбарт төсөл сонгон шалгаруулалт газрын биржийн [www.mle.mn](http://www.mle.mn) сайтад баталгаажуулан зарлах ажлыг зохион байгуулж, 75 нэгж талбарын дуудлага худалдаа танхим, цахимаар зохион байгуулж дэнчинг иргэдэд буцаан олголоо.

Газрын төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлтийг хүлээн авч баталгаажууллаа.

Барилга, хот байгуулалтын Сайд, Цахим хөгжил, харилцаа, холбооны Сайд нарын хамтарсан 2022 оны 227/A/76 тоот тушаалын дагуу “Хаягийн мэдээллийн системийг хэрэглээнд нэвтрүүлэх” арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэлтэй хаягийн мэдээллийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын хаягийн мэдээллийн санд бүртгэлтэй өгөгдөлтэй тулгах, нэгтгэх ажлыг эхлүүллээ.

Газрын кадастрын мэдээллийн систем 6 иргэн, аж нэгж байгууллагыг газрыг бүртгэж, 50 иргэн, хуулийн этгээд Газрын кадастрын мэдээллийн сангаар үйлчилсэн 9-н топлоги алдааг засварлаж ажилласан байна

### **ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Худалдан авах ажиллагаа, тендер шалгаруулалтын хүрээнд:** Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 22,546.4 сая төгрөгийн 78 төсөл, хөтөлбөр, арга хэмжээ тусгаснаас 17.103.7 сая төгрөгийн 62 төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөсөн. Боловсрол, шинжлэх ухааны сайдын шийдвэрээр 2023 онд 500.0 сая төгрөгийн 1 төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн.

04 сарын байдлаар 12,737.4 сая төгрөгийн 28 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тендер зарлахаас 11,563.7 сая төгрөгийн 21 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 75 хувь, сумдад 4,886.3 сая төгрөгийн 35 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд тендер зарлахаас 2,832.3 сая төгрөгийн 9 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд үнэлгээний хороо байгуулагдаж тендерийн явц 25 хувийн гүйцэтгэлтэй тус тус байна.

**Өмчийн ашиглалт, эзэмшилт, хамгаалалтын хүрээнд:** Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, МУЗГ-ын 2022 оны 204 дүгээр тогтоолын хэрэгжилт, аймгийн Засаг дарга, ИТХ-аас гаргасан бодлого, шийдвэрийн биелэлтийг хэрхэн хангаж буйд хяналт шалгалт хийж, зөрчил дутагдал арилгах, зөвлөгөө өгөх, шалган туслах ажлыг 27 суманд зохион байгууллаа.

### **ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

**Газар тариалангийн хүрээнд:** 2023 онд 127.3 мян.га талбайд тариалалт хийж, 325.8 мян.тн ургац хураан авахаар төлөвлөж, аймгийн Засаг даргын 04 дүгээр сарын 13-ны өдрийн А/248 тоот захирамжаар “Аймгийн тариалантын штаб”-ыг 13 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

№	Таримлын нэр	Тарих талбай (мян.га)	Хураан авах ургац (мян.тн)
1	Үр тариа	70.0	91.0
2	Буудай	60.6	78.7
3	Төмс	10.3	123.2
4	Хүнсний ногоо	2.0	26.6
5	Тэжээлийн ургамал	25.0	75.0
6	Тосны ургамал	20.0	10.0
7	Боловсруулах уринш /га/		85.0

Монгол Улсын хэмжээнд өрнөж байгаа “Хүнсний хувьсгал”, “Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”, “Тариалангийн сэргэлт”-ийн хүрээнд аймгийн нутгийн удирдлагын байгууллагаас хаврын тариалантын өмнөх зөвлөлдөх “Хаврын тариалантын зөвлөгөөн”-ийг 2023 оны 04-р сарын 18-ны өдөр Зуунмод суманд зохион байгуулж, 21 сумын 100 тариаланч, ногоочид хамрагдаж, ХХААХҮЯ, Ургамал хамгааллын Хүрээлэн, УЦУОШГ, ХААИС зэрэг мэргэжлийн байгууллагын багш, эрдэмтэд таримал ургамлын тариалалтад анхаарах асуудал, тариалантын зөвлөмж, шинэ дэвшилтэт технологи, дулааны улирлын цаг агаарын мэдээ өгч тариаланчдад хүргэн ажиллалаа. Зөвлөгөөнөөр хаврын тариалантыг хугацаанд нь зохион байгуулах, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч,

“Аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлого”, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн стратеги төлөвлөлт”, бүс нутгийн онцлогтоо тохируулан хэрэгжүүлж болох бусад орны сайн жишиг, туршлага, Төв аймагт хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлуудын талаар мэдээлэл хүргэлээ. Тус зөвлөгөөний хүрээнд “Үр тарианы зөвлөлдөх уулзалт”, “Төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний зөвлөлдөх уулзалт”-уудыг тус тус зохион байгууллаа.

2023 оны хаврын тариалалтад үр тарианы үр 11200 тн шаардлагатай байгаагаас 2022 оны ургацаас 10 сумын 64 аж ахуйн нэгж, иргэн 5964 тн үрийг нөөцөлсөн. Хаврын тариалалтын бэлтгэл ажлыг хангуулах ажлын хүрээнд газар тариалан бүхий 11 суманд тарих үрийн чанар, тариалангийн талбайн хөрсний доройтол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ургамал хамгаалах химийн бодис бордооны зохистой хэрэглээ, газар тариалангийн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас учруулсан хохирол тооцох арга хэмжээний зөвлөмж хүргүүлэн ажиллалаа.

#### **Мал аж ахуйн хүрээнд:**

Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд 2022 оны мал, тэжээвэр амьтны тооллогын жилийн эцсийн дүн мэдээг Үндэсний статистикийн хорооны мэдээлэлтэй тулгалт хийж, нэмж оруулах ажлын хүрээнд хөдөө аж ахуйн тасгийн малын бүртгэл хариуцсан мэргэжилтнүүдэд “Бүртгэлийн явцад үүсэж байгаа асуудлыг хэрхэн шийдвэрлэх” талаар ээлжит цахим сургалтыг зохион байгуулж ажилласан.

Мал төлөлт, төл бойжилт, том малын зүй бус хорогдлын мэдээг долоо хоног бүрийн Лхагва гарагт сумдаас авч нэгтгэн ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажиллалаа. 04 дүгээр сарын байдлаар оны эхний 2372086 толгой эх мал төллөхөөс нийт төллөх хээлтэгчийн 46.4 хувь буюу 1099505 толгой мал төллөж, 1101710 төл бойжиж, төл бойжилт 97.5 хувьтай байна. Том малын зүй бус хорогдлоор нийт мал сүргийн 0.8 хувь буюу 44150 толгой мал хорогдоод байна. Үүнд: адуу 2283, үхэр 2284, хонь 21746, ямаа 17235, тэмээ 2 толгой тус тус хорогдсон.

Төв аймгийн түүхт 100 жилийн ойг тохиолдуулан “ТӨВ ТҮМНИЙ АВАРГА МАЛЧИД”-ыг алдаршуулах, ХХААХҮЯ-наас зарласан “Малчдыг дэмжих анхдугаар аян”-ы хүрээнд улс, аймгийн аварга малчид оролцсон “Төв түмний аварга малчид” зөвлөгөөнийг Алтанбулаг, Баянчандмань, Баян, Эрдэнэ, Лүн сумдад бүсчилэн зохион байгууллаа.

**Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд:** Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1023.0 мян.тол мал, амьтан хамруулаар төлөвлөн эм биобэдмэлийн татан авалт 71.5 хувьтай байна. Баянжаргалан суманд бог малын мялзан, Баянцогт суманд хонины цэцэг өвчин оношлогдон хорио цээр, хязгаарлалтын дэглэм цуцлагдан тайван байдалд шилжсэн.

Баянцагаан сумын Хөндлөн гэх газарт хонины цэцэг өвчин оношлогдон 11600 толгой хонийг дархлаажуулан 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрөөс хорио цээрийн дэглэм тогтоон 1.5 мян/м2 талбайд халдваргүйтгэл хийж, 1 суурийн хяналтын цэгт 24 цагаар 2 албан хаагч үүрэг гүйцэтгэж байна. Мал эмнэлгийн Ерөнхий газраас 100н жилийн ойг угтан зохион байгуулсан олон төрөлт спортын арга хэмжээнд 20 албан хаагч оролцлоо.

Монгол улсын дасан зохицлын нэгдсэн төлөвлөгөөний төсөлд санал өгөхөөр 3 албан хаагч, Монгол улсын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал өгөхөөр 3 албан хаагч хамрагдлаа. Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх 15 серийн дугаартай 363.8 мян.тун вакцин татан авч аймгийн Засаг даргын А/273 тоот захирамж, газрын даргын А/20 тоот тушаалаар 27 суманд хувиарлан 2023 оны 04 дүгээр сарын 17-ноос 05 дугаар сарын 12-ны хооронд зохион байгуулахаар эхлүүлээд байна.

Зүй бусаар хорогдсон 21904 толгой мал, амьтны сэг зэмийг булж устган 138.2 мян/м2 талбайг халдваргүйтгэн 401.5 кг бодис зарцуулсан. Малын эмч нарт итгэмжлэлийн багц цаг олгох сургалтыг 2 хоног Зуунмод суманд зохион байгуулж 25 малын эмч амжилттай хамрагдлаа. Тайлант хугацаанд 44355 мал, амьтан, мах, махан бүтээгдэхүүн 287.6 кг, сүү, сүүн бүтээгдэхүүн 1264.7 литр, өндөг 11.6 сая ширхэг, ноолуур 58.2 кг, 378 ширхэг арьс ширд нийт 2816 мал эмнэлгийн гэрчилгээг олгожээ.

Лүн суман дахь Мал эмнэлгийн хяналтын цэг 4 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа нийт 388- тээврийн хэрэгсэл, амьд мал нийт-4206 толгой. Тэмээ-4 адуу-946, үхэр-436, хонь-1320, ямаа-212, Мах нийт-126372кг адуу мах-1300 кг, үхэр мах-21326 кг, хонь мах-52350кг, ямаа мах-51396, Түхий эд-2500-кг, Цагаан идээ-2400 кг, ноолуур 72тн, ямааны арьс-2500 ширхэг арьсанд эрүүл ахуйн үзлэг хийн нийт-410 мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийж ажиллалаа.

Нян судлалын лабораторит Лүн сумын үхрийн дээжинд колибактериоз, цусан халдварыг илрүүлэх нян судлалын шинжилгээ хийхэд сөрөг гарсан. Архуст суманд хонинд ДХХ оношлогдсон ба УМЭАЦТЛ-т илгээн баталгаажуулав. Баянцагаан сумын хонины дээжийг хонины цэцэг өвчин оношлуулахаар УМЭАЦТЛ-т илгээв. Тус дээж эерэг гарав. Шимэгч судлалын лабораторит адууны нийлүүлэгийн өвчин оношлох шинжилгээнд 41 адуу хамруулснаас 5 адуу эерэг гарсныг УМЭАЦТЛ-т илгээн баталгаажуулав. Ийлдэс судлалын лабораторит Сэлэнгэ аймгаас Зуунмод суманд үржүүлгийн зорилгоор ирсэн 2 буханд бруцеллөз, үхрийн лейкоз өвчний шинжилгээ хийхэд сөрөг гарсан. Ариун цэвэр, магадлан шинжилгээний лабораторит Зуунмод сумын худалдаанд борлуулах зориулалттай хонины махны 2 дээжинд антибиотикийн үлдэгдэл илрүүлэх шинжилгээг хийхэд сөрөг гарлаа.

Зорилтот тандалтын ажлын хүрээнд 27 суманд шүлхий өвчний байгалийн халдварыг бог малд, бог малын мялзан өвчний байгалийн халдварыг бог малд үзэх тандалт шинжилгээний хүрээнд өнөөдрийн байдлаар 1995 дээж ирж хэрэгжилт 77 хувьтай байна.

#### **Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний хүрээнд:**

ХХААХҮЯ-ны сайдын 2023 оны А/37 дугаар тушаалаар ЖДҮХСангаас 900.0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэр хуваарилагдсан. Хөнгөлөлттэй зээлд хамрагдах 4.5 тэрбум төгрөгийн 27 төслийн материалыг хүлээн авч, эхний шатны шалгаруулалт баримт бичгийн иж бүрдэл шалгах ажлыг зохион байгуулж, 1.2 тэр бум төгрөгийн 7 төсөл хэрэгжүүлэгчийн материалыг дараагийн шатанд шилжүүлэх ажлыг зохион байгууллаа:

Хөгжлийн шийдэл ТББ-ын хэрэгжүүлж буй “БЭСТ” төсөлтэй хамтран “Хоршооны сайн засаглал” сэдэвт сургалт зохион байгуулж 23 хоршооны 38 төлөөлөл хамрууллаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ЖДҮГазар, Монгол банк, Зээлийн батлан даалтын сантай хамтран бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийн санхүү сургалтад 5 сумын 42 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид хамрагдлаа. “Хангайн бүсийн аварга тогооч шалгаруулах ур чадварын уралдаан” тогооч нарын аварга шалгаруулах тэмцээнд 17 тогооч 19 төрлөөр амжилттай оролцлоо.

Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 12 сумын 38 иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг хянан Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн санд бүртгэлгүй болголоо.

#### **СТАНДАРТ ХЭМЖИЛ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Тохирлын үнэлгээнд хамрагдах, сунгуулах хүсэлтийн дагуу Зуунмод, Сэргэлэн, Борнуур, Эрдэнэ сумын 17 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүн үйлчилгээг холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээнд хамрууллаа. Баталгаажуулалтын орон тооны бус зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн 40 аж ахуйн нэгж, иргэний 26 худалдаа, 1 ресторан, 3 баар, 2 дэн буудал, 1 кафе, 1 бизнес лоунж, 6 амралтын газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаагаар шинээр олголоо. Стандартын мэдээлэл лавлагааны үйлчилгээг 29 аж, ахуй нэгж иргэдэд үзүүлж 3 байгууллагад 17 нэр төрлийн стандарт олгож, Баян-Өнжүүл, Бүрэн, Баянцогт, Жаргалант, Лүн, Өндөрширээт, Эрдэнэ сумдын худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд “Стандарт, тохирлын баталгаажуулалтын ач холбогдол” сургалтыг цахимаар зохион байгууллаа.

Массын хэмжлийн төрлөөр Зуунмод, Баян, Заамар сумын худалдаа үйлчилгээ, нийтийн хоол үйлдвэрлэлийн 62 ш массын хэмжих хэрэгсэл, Зам тээвэр хөгжлийн төвийн Эрдэнэсант суманд байрлах ХК3190-М1 маркын 50т хэмжих хязгаартай 2 динамик жин, Жаргалант сумын Тэн хун ХХК-ний ХК3190 маркын 100т даацтай автомашин жинг тус тус шалгаж баталгаажууллаа. Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн, Өндөрширээт сумуудын айл өрх, АА-н нэгжүүдийн мөнгөн тооцоонд ашиглагдаж байгаа 1106 ш 1 ба 3 фазын цахилгаан тоолуур, Зуунмод сумын Усны АА-н айл өрхийн 65ш 1фазын цахилгаан тоолуурт ээлжит баталгаажуулалт хийсэн.

Итгэмжлэгдсэн лаборатори нь 109 сорьцыг шалгаж хүлээн авч 264 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулаа

#### **БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР**

**Хог хаягдлын хүрээнд:** Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын 2023 оны 02 дугаар албан даалгаварын хүрээнд Аймгийн Засаг даргын 2023 оны 03 сарын 01-ны өдрийн 01 дүгээр албан даалгавар гарч, аймгийн хэмжээнд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Бүх нийтийн цэвэрлэгээнд аймгийн хэмжээнд нийт 109 төрийн болон аж ахуйн нэгж байгууллага, 2972 иргэн оролцож, 742.9 тн хог хаягдал, 2512 сэг зэм цэвэрлэлээ. Хог хаягдлыг

эх үүсвэр дээр нь ангилан ялгаж авах зориулалтын цэгийг Зуунмод суманд 2 цэгт бий болгон дахивар хаягдлыг авч байна.

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын 2023 оны 04 сарын 19-ны өдрийн 07/132 дугаар албан тоотор сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй амралт, аялал жуулчлалын бааз, зам дагуух үйлчилгээний газар болон нийтийн эзэмшлийн стандартын бус нүхэн жорлонг буулгах тухай мэдэгдлийг аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлэн, буулгасан нүхэн жорлонг ариутгах, нөхөн сэргээлт хийх, стандартын шаардлага хангуулах (MNS5924:2015 Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага) ажлыг 2023 оны 04 дугаар сард багтаан зохион байгуулахыг мэдэгдлийг хүргүүллээ.

## **ДОЛОО. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:**

### **Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л зүйлд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилготой “Аз жаргалын өргөө” хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөгжлийн төвийн барилгын засварын ажлыг Холт олон улсын байгууллагын 240.7 сая, Орон нутгийн 19.8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгтэй эхлүүлж, барилгын засварыг 2023 оны 07 дугаар сарын 05 өдөр бүрэн дуусгахаар ажиллаж байна.

Эерэг хандлага-Эрүүл мэнд", "Энэ жилдээ-Эрүүл жиндээ", "Илүүдэл жингүй-Эртэч Төв аймагчууд", "Дугуйтай Төв аймагчууд" аяны нээлтийн арга хэмжээг зохион байгуулж, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудыг аянд нэгдэхийг уриаллаа.

Төв аймгийн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж байгаа спорт бүжгийн аймгийн аварга шалгаруулах “Цагаан сарнай-2023” тэмцээнийг 2023.04.14-ний өдөр зохион байгуулж 15 сумын 16 багийн 278 тамирчин оролцлоо.

“Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” үндэсний форумд НБХ-ийн дарга “Орон нутгийн түвшинд Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлт” бичил төслийг хэрэгжүүлсэн туршлага, сургамж сэдвээр илтгэл мэдээлэл тавьж, аймгаас 6 төрийн албан хаагч танхимаар, 100 гаруй албан хаагч цахимаар оролцлоо.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн салбар комиссын хурлыг Эрдэнэ суманд 04-28-ны өдөр зохион байгуулж “Кейс хэлэлцүүлгийг” салбар дундын оролцоог ханган зохион байгууллаа.

Японы нүдний эмч профессоруудын ХҮМҮҮНЛЭГИЙН ХОЛБОО-той хамтран АНЭ-т нүдний болор суулгах болон бусад нарийн мэс заслыг хийх боломж бүрдүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдаж, эмчийг сургаж дадлагажуулах ажлыг эхлүүллээ.

Харьяа 8 агентлаг, 5 байгууллагад зөвлөн туслах удирдамжийг батлуулан 04-р сарын. 17-21-ний өдрүүдэд 13 байгууллагад хэлтсийн 5 мэргэжилтэн, даргын хамт ажиллаж, салбарын түвшинд хэрэгжиж байгаа бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилт явц, удаашралтай ажил арга хэмжээг эрчимжүүлэх зөвлөмжийг байгууллага бүрд албан тоотор хүргүүллээ.

### **ГЭР БҮЛ ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР:**

#### **Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүдийг чадавхжуулах “Ментор-2023” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагааг Төв аймагт зохион байгууллаа. Ментор хөтөлбөрийн үр дүнд Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд гэмт хэргийн гэрч, хохирогч хүүхэд болон хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас суллагдсан насанд хүрээгүй хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний чанар хүртээмж сайжирч, кейс шийдвэрлэлтийг эрчимжүүлж дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах чадвартай мэргэжилтэн бэлтгэгдэх юм.

Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Бүрэн, Дэлгэрхаан, Эрдэнэсант сумдын Ерөнхий боловсролын сургуульд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд өсвөр үе, хүүхдэд чиглэсэн сургалт нөлөөллийн үйл ажиллагаанд 640 сурагч, Боловсролын салбар дахь хүүхэд хамгаалал, хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтад 92 эцэг, эх, асран хамгаалагч, багш нарыг хамруулж, сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө, үйлчилгээг 11 хүүхдэд өгч ажиллалаа.

#### **Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

"Өсвөр насны хүүхдийн онцлог, хүүхэдтэйгээ харилцахад анхаарах асуудлууд" "Гэр бүлийн болон хамт олны харилцаа хандлага", "Гэр бүл төлөвлөлт, хүүхэд хүмүүжлийн эерэг арга" "Зан үйлээ засах сэдэвт сургалтуудыг Зуунмод сумын 67 иргэнийг хамруулан зохион байгууллаа.

Төв аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй сумдын хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах бүсчилсэн сургалтыг зохион байгуулж Батсүмбэр, Баянчандмань, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Баянцогт, Заамар, Угтаалцайдам, Цээл сумдын нийт 86 албан хаагчийг хамрууллаа. Сургалтаар Хамтарсан багийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, үйлчилгээний чадавхыг бэхжүүлэх, хамтарсан багийн гишүүдэд кейс менежмент хийх үе шат, кейс файл бүрдүүлэх, гишүүдийн ур чадварыг сайжруулах, арга зүйн дэмжлэг үзүүллээ.

Долоо хоног бүрийн Баасан гарагийн 17:00 цагт “ГЭР БҮЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ЦАГ” мэдээллээр “Хүүхдийг зодож шийтгэхгүй байх” “ Гэр бүлийн амьдралдаа хэрэгжүүлэх 10 зөвлөмж”, “Амжилттай гэрлэлтийг бүтээхийн тулд хосууд бие биеэ илүү танин мэдэж, хүлээн зөвшөөрч, харилцааны зөв загвартай байх хэрэгтэй байдаг” зэрэг сэдвээр мэдээлэл бэлтгэн, байгууллагын цахим хаягт байршуулж, иргэдэд мэдээлэл хүргэж байна.

Гэр бүл төлөвлөлт, гэр бүлийн үнэ цэнэ сэдвийн хүрээнд Алтанбулаг суманд байрлах Зэвсэгт хүчний 119-р анги, Зуунмод суманд байрлах 016-р анги нэгтгэлийн офицер, ахлагч, ажилтан, тэдний гэр бүл, хугацаат цэргийн алба хаагч нийт 172 иргэнийг хамруулан /эмэгтэй 21/ сургалт, өдөрлөгийн арга хэмжээг зохион байгууллаа.

#### **Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Хар тамхи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг зөрчилд өсвөр насны хүүхэд, залуучуудыг холбогдохоос урьдчилан сэргийлэх, иргэд, олон нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх зорилготой #АНЗААР аяны арга хэмжээг ЦЕГ-ын хар тамхитай тэмцэх газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, ГХУССЗөвлөл, Цагдаагийн газар, ГБХЗХГ-ын Залуучуудын хөгжлийн төв, Баянчандмань сумын ИТХ, ГХУСЗ, ЗДТГазартай хамтран зохион байгууллаа. Анзаар аяны нээлтийн арга хэмжээнд нийт 70 гаруй байгууллага, ААН-ийн 2865 хүн хамрагдаж сургалт мэдээлэл авлаа.

Монголын үндэстний уламжлалт зан үйлийн өргөө” НҮТББ, Монголын ураг удам, уламжлалын холбоо” НҮТББ, “Тэнгэрийн сургуулийн хайрын тэнхим” НҮТББ-уудтай хамтран “Бид эх түүхийн эзэд” өв соёл, ураг, удмын бичгийн талаарх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг Эрдэнэ сумын МСҮТ, Баянчандмань сумын Коллеж, Зуунмод сумын Политехник коллежийн нийт 242 оюутан сурагчид, багш ажилчдыг хамруулан зохион байгууллаа.

#### **НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХҮРЭЭНД:**

Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс ирүүлсэн 19 өргөдөл, гомдол, 17 албан бичгийг хүлээн авч 17 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн хариу өгч ажиллалаа.

“Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-д зааснаар иргэний нэхэмжлэлтэй шүүх хуралд хяналт шалгалт, дотоод аудитын тасгаас 1 удаа нийгмийн даатгалын хэлтсийг төлөөлж гуравдагч этгээдийн үүргээр татагдан оролцож иргэний талд шийдвэр гаргуулж ажилласан.

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 5 удаа 33 цаг хуралдаж, нийт 240 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 23 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг тогтоож, 201 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 2 иргэнийг буцааж, 14 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг цуцаллаа.

#### **Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:**

Хамтран ажиллах гэрээний дагуу Хаан, Төрийн банкаар 17936 тэтгэвэр авагчдад 8,9 тэрбум төгрөгийн тэтгэврийг олголоо.

#### **ХӨДӨЛМӨР ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД:**

##### **Нийгмийн халамжийн чиглэлээр:**

2023 оны 4-р сарын байдлаар нийгмийн халамжийн тэтгэвэр 1866 иргэнд 2093,5 сая төгрөг, нөхцөлт мөнгөн тэтгэмж 1153 иргэнд 415,5 сая төгрөг, онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж 9 иргэнд 10,8 сая төгрөг, амьжиргааг дэмжих мөнгөн тусламж 287 иргэнд 315,2 сая төгрөг, алдарт эхийн одонтой 9454 иргэнд 1218,9 сая төгрөг, ахмад настны хөнгөлөлт тусламжид 3094 ахмад настанд 103,4 сая төгрөг, Насны хишиг 5857 иргэнд 475,6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт тусламжид 497 иргэнд 48,3 сая төгрөг, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ 2337 иргэнд 104,6 сая төгрөг, жирэмсэн 791 эхэд 96 сая төгрөгийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсны тэтгэмж 3922 иргэнд 712,2 сая төгрөг, 3 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт олгох тэтгэмж 301 иргэнд 166,6 сая төгрөг,

ихэр хүүхдийн тэтгэмж 7 иргэнд 14 сая төгрөг, Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 32965 хүүхдэд 1333,0 сая төгрөг тус тус олгосон.

Шинээр төрсөн 80 хүүхдийн мэдээллийг и-халамж системээр бүртгэж, Хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой журам, чиглэлийн талаар 70 гаруй иргэнд мэдээлэл өглөө.

Нийгмийн хөгжлийн чиглэлээр: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь 04 дүгээр сард 12 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг сунгаж, 3 хүүхдийн хөгжлийн бэрхшээл болон байнгын асаргааг тогтоолоо. Нийт 15 хүүхдийн асуудлыг хэлэлцэж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хамрагддаггүй 2 хүүхдийг хувилбарт сургалт, цэцэрлэгт хамруулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өглөө.

Жайка олон улсын байгууллагатай хамтарч Эрдэнэ суманд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн Кейс хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгээр хүүхэд, гэр бүлийн асуудал бэрхшээлийг тодорхойлж, хөгжлийн төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

#### **Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

Аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлийн анхдугаар хуралдааныг зохион байгуулж, зөвлөлийн үйл ажиллагааны 2023 оны төлөвлөгөө болон ХЭДСанд хуваарилагдсан Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилтийг иргэдийн санал, хүсэлтэд тулгуурлан, оролцоог тэгш хангах зарчмын хүрээнд зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Ejob программд 4-р сарын байдлаар 18 ажил олгогч, 119 иргэн ажил хайгчаар бүртгэгдлээ.

Нийт 28 ажил олгогчийн 112 сул чөлөөтэй ажлын байрны захиалгыг хүлээн авч 28 /нийт 80/ иргэнийг байнгын ажлын байранд, түр ажлын байранд 456 иргэнийг зуучиллаа.

Шинээр бий болсон 24 ажлын байрыг бүртгэн баталгаажуулснаас түр шинэ ажлын байр 7, байнгын шинэ ажлын байр 17 бүртгэгдлээ. /нийт ШАБ 156 үүнээс: байнгын шинэ ажлын байр - 146, улирлын шинэ ажлын байр - 2, түр шинэ ажлын байр - 8/ бий болсон байна.

#### **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр**

ХАБЭА-н аймгийн зөвлөлийг аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн байгуулж, анхдугаар хуралдаанаа зохион байгууллаа. Хуралдаанаар ХАБЭА-н аймгийн зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ХАБЭА-н сарын аяны төлөвлөгөөг хэлэлцэн баталж, ХАБЭМэндийн хөтөлбөрийг 2021-2025 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахаар шийдвэрлэлээ.

ХАБЭА-н сарын аяныг “Эрүүл, аюулгүй ажлын байр-Бидний суурь эрх” уриан дор зохион байгуулж байгаа бөгөөд төлөвлөгөөний дагуу сумдын ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг Лүн, Баянчандмань, Эрдэнэ сумдад бүсчлэн танхимын сургалтыг зохион байгууллаа. Төв Чандмань ДЭХГазар, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Төрийн үйлчилгээний нэгдсэн төв зэрэг байгууллагуудын нийт 200 орчим ажилтнууд болон 80 гаруй иргэдэд ажлын байрны эрсдэлийг хэрхэн илрүүлэх, ХАБЭА-н тухай хууль нь хөдөлмөрийн тухай хуультай нягт холбоотой байгааг таниулах сургалтуудыг зохион байгууллаа.

Уул уурхайн салбарт үйлдвэрлэлийн осол нэмэгдсэнтэй холбогдуулан аврах үйл ажиллагааг хэрхэн үзүүлэх, ажлын байрны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, холбогдох хууль дүрэм, тогтоол журмуудад ямар өөрчлөлт орсон зэргийг сурталчлан таниулах зорилгоор Заамар суманд үзүүлэх сургалтыг зохион байгуулж чадавхжууллаа. Сургалтад аймгийн нутаг дэвсгэрт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 28 байгууллагын 60 гаруй төлөөлөл оролцлоо.

#### **Бусад чиглэлээр**

Байгууллага сурталчлах, үйл ажиллагааны мэдээлэл хүргэх нээлттэй хаалганы өдөрлөгийг Борнуур, Бүрэн сумдад нийт 180 гаруй иргэдийг хамруулан зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний эргэн төлөгдөх санхүүгийн дэмжлэг, бусад арга хэмжээг иргэд олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулж Бүрэн, Борнуур, Зуунмод, Баян, Эрдэнэ, Алтанбулаг, Эрдэнэсант сумдад ажиллалаа.

#### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Аймгийн хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын байдлаар 218 эх төрж өнгөрсөн оны мөн үеэс 39 тохиолдлоор өссөн ба 220 нярай мэндэлсэн байна. Жирэмсний хяналтад нийт 691 эх байгаагийн 302 эхийг шинээр хяналтад авсан бөгөөд эхний 3 сартай хяналтад 94.70% хамрагдсан. Нийт 84099 хүнд үзлэг хийсэн, үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 20135, амбулаторийн үзлэг 53851, идэвхтэй хяналтын 6047 хүнд үзлэг хийсэн байна.



Түргэн тусламжийн дуудлагаар 4097 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлээ. Стационарт 4533 хүн эмчлэгдэн нийт 32971 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 7,3 байна.

Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/135 дугаар тушаалаар Баян, Дэлгэрхаан, Баянцогт сумын Эрүүл мэндийн төв 2 жилээр, Арга билэг сувилал 4 жилээр, Замтын булаг сувилал 3 жилээр, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/108 дугаар тушаалаар Нэгдсэн эмнэлэг 4 жилээр, Аксион мэдрэлийн эмнэлэг 3 жилээр тус тус магадлан итгэмжлэгдлээ.

Эрүүл мэндийн газрын даргын батлагдсан удирдамжийн дагуу ажлын хэсэг Алтанбулаг, Угтаалцайдам, Дэлгэрхаан, Баянжаргалан сумдад зөвлөн туслахаар ажиллаж, Эрүүл мэндийн салбарын нээлттэй хаалганы өдөрлөгийг 5-р багт амжилттай зохион байгууллаа. Тус өдөрлөгийн хүрээнд иргэдэд эрүүл амьдралын дадал хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор амны хөндийн эрүүл ахуй, эрүүл зөв хооллолтын хэв маягийн талаарх үзүүлэн сургалт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө зөвлөмж өгч нийт 156 иргэнийг урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрууллаа. туслах баг ажиллаалаа.

ДЭМБ-аас өвөлжилт хүндэрсэн Төв аймгийн 17 суманд эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чадавхыг сайжруулах төслийн хүрээнд 17.0 сая төгрөгийн шатахууныг шийдвэрлэлээ. Мөн эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтын дагуу хөдөө орон нутагт 3 болон 5 жил тогтвор суурьшилтай ажилласан 6 ажилтанд 30.7 сая төгрөгийн мөнгөн тэтгэмж олголоо.

“Өсвөр үеийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал” салбар дундын хэлэлцүүлгийг ААНБайгууллагын удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан санал зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна

Аз жаргалтай төвийн үйл ажиллагааны хүрээнд Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжлийн ерөнхий газрын мэдрэл, дотор, сэтгэл зүйч, шүдний нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт 18 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулан, хөдөлгөөнийг тодорхойлох үнэлгээ хийж, зөвлөгөө өглөө. Мөн НЭМҮТ-ээс зохион байгуулсан “Хүнд металлын хордлогыг илрүүлэх” судалгаанд 98 хүнийг хамрууллаа.

Аймгийн Цэргийн штаб, Цэргийн төв эмнэлэг, хамтран Өрх, сумын Эрүүл мэндийн төвийн дарга, эмч нарыг сургалтад хамруулж, мэдээлэл солилцлоо. Хугацаат цэргийн албанд эрүүл мэндээр тэнцэхгүй 100 гаруй иргэнийг Цэргийн Төв эмнэлгийн комиссын үзлэгт хамруулах үйл ажиллагааг зохион байгууллаа. Мөн ЭМГ, АНЭ хамтран Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн ажилтан албан хаагчид, хугацаат цэргийн анги бүрэлдэхүүн 400 гаруй хүнд эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, сүрьеэгийн илрүүлэг үзлэгт 80 хүнийг хамруулан сүрьеэгийн сэжигтэй 3 хүнийг нарийн шинжилгээнд явуулж зөвлөгөө өгч ажиллалаа.

Халдварт өвчний сэжигтэй тохиолдлыг мэдээлэх хуудасны дагуу салхин цэцэг 33, Энтеровирус-17, Цусан суулгын 2, Дизентри өвчний 1 тохиолдолд тандалт судалгаа хийж, хариу арга хэмжээ авч ажилласан. Хачигт халдварын сэжигтэй 3 тохиолдлын тандалт судалгааг хийж, сорьцыг цуглуулж ЗӨСҮТ-д хүргүүлсэн. Мөн Салхин цэцэг, Энтеровируст халдвар гар хөл амны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргаж ЕБС, СӨБ-д хүргүүллээ.

Хими, нян судлалын лабораторид унд ахуйн усны 32 сорьц, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хүсэлтийн дагуу 56 сорьц нийт 86 сорьцод шинжилгээ хийлээ.

Монголын цус сэлбэлт судлал Эмч Мэргэжилтнүүдийн Нийгэмлэг, Төв аймгийн Эрүүл мэндийн газар хамтран Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний шатлал бүрд ажиллаж байгаа эмнэлгийн эмч, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг цусны бүлэг, хувийн тохироо, тодорхойлох шинжилгээний аргачлалд сургах, цусны аюулгүй байдлыг хангахтай холбоотой цогц мэдлэг олгох болон цус сэлбэх үйл ажиллагаанд хариуцах ажил үүрэг, холбогдох заавар журам, баримтжуулалтыг бүрэн хөтлөх мэдлэг, ур чадвар олгох зорилгоор онол, дадлага хосолсон сургалт 2023 оны 04 дүгээр сарын 14, 15-ны өдрүүдэд зохион байгуулагдан сургалтад Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, 26 сум, өрхийн Эрүүл мэндийн байгууллагын нийт 125 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдлаа.

4-р сарын байдлаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах 5 удаагийн сургалтад 221 эмч эмнэлгийн мэргэжилтнүүд, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох 9 удаагийн сургалтад 636 иргэнийг хамрууллаа.

#### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХҮРЭЭНД:**

Даатгуулагч иргэдэд тусламж үйлчилгээ үзүүлсэн 74 эрүүл мэндийн байгууллагаас нийт 25 төрлөөр санхүүжилтийн нэхэмжлэлийг хүлээн эвч чанарын хяналт явуулж, санхүүжилт олгох зөвшөөрлийг ЭМДЕГ-т хүргүүллээ. 2023 онд 44 эмийн сантай гэрээ байгуулахаар

зөвлөмж, албан тоотыг хүргүүлж, 41 эмийн сангийн гэрээний төслийг нэг бүрчлэн хянаж ЭМДЕГ-т хүргүүллээ.

### **БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ХҮРЭЭНД:**

Боловсролын ерөнхий газрын зөвлөн туслах баг “Сургуулийн менежментийг сайжруулах” жилийн хүрээнд Хүмүүн цогцолбор сургууль, Батсүмбэр сумын ЕБС-ийн удирдлага, багш нарт Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, багшийн хөгжил, Сургуулийн удирдлага, манлайлал, Сургуулийн менежмент, Хүүхэд хөгжил, хамгаалал, Сургалтын орчин гэсэн чиглэлээр ажиглалт үнэлгээнд үндэслэн зөвлөн тусаллаа.

Бүтээлч багачууд шилдэг арга зүй уралдааныг 1-2-р анги, 3-4-р анги, 5-р анги, багш гэсэн 4 төрлөөр 1,2-р шатыг зохион байгуулж, тус уралдаанд 248 багш, 1-2-р ангийн 138 баг, 3-4-р ангийн 148 баг, 5-р ангийн 91 баг нийт 377 баг оролцлоо.

СӨБ-ын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд Сургуулийн өмнөх байгууллагын 37 цэцэрлэгийн 1599 хүүхэд оролцохоос 1398 хүүхэд оролцож, оролцоо 87.4% байна.

Монгол хэл бичгийн шалгалтыг Хүмүүн цогцолбор сургуулийн шалгалтын төв д зохион байгуулж, шалгалтад 660 шалгуулагч оролцохоос 632 шалгуулагч оролцлоо.

Унших ба тоо бодох чадварыг хөгжүүлэх арга зүй” сайн туршлагын зөвлөгөөнд 30 сургуулийн 30 багш монгол хэл, математикийн шинэлэг арга зүйн санаа бүхий хичээл зааж, сайн туршлагын 38 илтгэлээ танилцуулан оролцлоо.

ЕБ-ын сургуулиудад ЭЕШ-ын явцын үнэлгээ хийж, бэлтгэл ажлыг эрчимжүүлэн, багш сурагчдыг урамшуулан дэмжих зорилгоор УИХ-ын гишүүн Ж.Батжаргалын нэрэмжит “Амжилтын хөтөч” ЭЕШ-ын сорилгыг зохион байгууллаа.

“ӨВ СОЁЛОО ЭРХЭМЛЭЖ ҮНДЭСНИЙ БИЧГЭЭ СУРЦГААЯ- 2025” аяны хүрээнд аймгийн хэмжээнд үндэсний бичгээ сурах аян өрнүүлж монгол бичгийн сургалтыг зохион байгуулах хуваарь гарган ажиллаж байна.

### **СОЁЛ, УРЛАГИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Соёлын яам, Төв аймгийн Соёл, урлагийн газар, Чингис хаан Үндэсний музей хамтран Төв аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан "Соёлын төв-Соён гэгээрлийн төв" мэргэжил арга зүйн зөвлөгөөнийг зохион байгуулсан. Сумдын соёлын төвийн үйл ажиллагааг сайжруулахад албан хаагчдын мэдлэг, мэргэжил ур чадварыг сайжруулах зорилго бүхий энэхүү сургалт, зөвлөгөөнд Төв аймгийн сумдын Засаг дарга нар, 27 сумын Соёлын төвийн 170 гаруй ажилтан, албан хаагчид хамрагдлаа.

### **НИЙТИЙН НОМЫН САН**

Тухайн сард 257-н байнгын уншигч, 1409 ирэгсэд, нийт 1666 уншигчдад 3254 ном олгож үйлчилсэн байна. Нийт 257 уншигч шинээр карт нээлгэснээс 110 эрэгтэй, 147 эмэгтэй уншигч байна.

Нийтийн номын санд төсвөөр 52 ширхэг 1.004.900 төгрөгийн ном, хандиваар 30 ширхэг 1.446.000 төгрөгийн ном нийт 82 ширхэг 1.288.700 төгрөгийн номыг нэг бүрчилсэн бүртгэл болон электрон каталогит оруулж уншигчдын хүртээл болголоо.

Аймгийн нийтийн номын сангаас “Дэлхийн хүүхдийн номын өдөр”-ийг угтан Хүүхдийг уран зургаар дамжуулан дотоод ертөнцөө нээх, бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, ном унших, номын утга агуулгыг ойлгон ухаарч өөрийнхөөрөө сэтгэх, номын сангийн хөгжилд хүүхдийн оролцоог нэмэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүсэл мөрөөдлийг тэдний нүдээр харах зорилгоор “ҮЛГЭРЭЭР ХҮМҮҮЖҮҮЛЬЕ” гар зураг болон бүтээлийн уралдааныг ЕБС-ийн 1-6 ангийн сурагчдын дунд амжилттай зохион байгуулж 7 сумын 117 бүтээл оролцлоо.

Төв аймгийн нийтийн номын сангаас “НАРХАН ХҮҮХЭД ХӨГЖЛИЙН ТӨВ”-ийн үйл ажиллагаатай танилцаж цаашид хөгжлийн төвийн хамт олонтой хамтран ажиллахаар санал хүсэлтээ солилцлоо. Хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор Хүүхдийн уран зохиол, Үлгэр, Оньсого, Хичээнгүй бичиг, Буддаг ном зэрэг 17 ширхэг номоор номын хандив өргөн, зөөврийн номын сангийн үйлчилгээгээр бяцхан хүүхдүүддээ зориулж сонсдог 5 ширхэг номыг 1 сарын хугацаатай олголоо.

### **Монгол Туургатан театр**

Панжилова Рыжковагийн зохиол “ ШИВШЛЭГТЭЙ ЗУРГИЙН НУУЦ” хүүхдийн жүжиг, Г. Мишээлийн зохиол “ САРЬСАН БАГВААХАЙН ДОМОГ” хүүхэддэйн жүжгийг Говьсүмбэр аймагт очиж тоглолоо.

Монгол туургатан театрын бүжгийн СТА Б. Мөнгөнцоожийн анхны бие даасан “МОНГОЛ БҮСГҮЙ” тоглолт, “ИХ ХҮНДЭТГЭЛ-80” хүндэтгэлийн тоглолт, Зуунмод сумын ЗДТГ, аймгийн Ахмадын хороотой хамтран 6 багийн ахмадуудын дунд “ДУУН ЦЭНГҮҮН-2023”, арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

### **Музей**

Музейд Угтаал-цайдам сумын харьяат ахмад сурган хүмүүжүүлэгч Л.Бавуугийн "Онъсон бүтээл"-ийн үзэсгэлэн үргэлжлэн гарч байна. Тус үзэсгэлэнг нийт 1095 иргэн, үүнээс 585 хүүхэд үзээд байна.

Музейн төслийн багаас музейд ажиллаж байгаа Койка Олон улсын байгууллагын сайн дурын ажилтантай хамтарч “Манзуширын байгалийн музейд Хүрээлэн буй орчны боловсрол” сэдэвт боловсролын танхим байгуулах, Хүүхдүүдэд зориулсан музейн боловсролын ажил явуулах 40,0 сая төгрөгийн төсөл бичиж, Монгол дахь Койка Олон улсын байгууллагын төслийн шалгаруулалтад хүргүүлээ.

### **БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ТАЛААР:**

МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Цаг гаргая” аргая хэмжээ, БТСУХ-ноос 2023.04.01-ын өдрөөс 2023.11.30-ний хооронд улс орон даяар зарлан явуулж байгаа “Эерэг хандлага-Эрүүл нийгэм” БТС-ын салбарын ажиллагсад, тамирчид, дасгалжуулагчид, шүүгчдийн ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх аянуудын цахим сургалтуудад багш, дасгалжуулагчид, албан хаагчдыг бүрэн хамрууллаа.

МУ-ын ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн” хөтөлбөр, “Алсын хараа-2050” урт хугацааны бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор “Цаг гаргая”, “Эерэг хандлага- Эрүүл нийгэм” аянд Төв аймгийн 27 суманд Туг, дэвтэр аялах бөгөөд Эрдэнэ, Баянчандмань, Алтанбулаг сумдаас эхлүүлээд байна.

2023 оны өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын ширээний теннисний аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023.04.01-02-ны өдрүүдэд Баянчандмань суманд зохион байгуулж 5 сумын 6 багийн 214 тамирчин оролцлоо.

МУ-ын гавьяат тамирчин, дэлхийн хошой Г.Үүрцолмонгийн нэрэмжит Самбо бөхийн өсвөр үеийн улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2023.04.06-09-ны өдрүүдэд Зуунмод суманд зохион байгуулж 20 аймаг 9 дүүргийн 51 багийн 1460 тамирчин оролцлоо.

2023 оны өсвөр үе, насанд хүрэгчдийн Шагайн харвааны аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023.04.08-09-ны өдрүүдэд зохион байгуулж 20 сумын өсвөрийн 6 багийн 48, насанд хүрэгчдийн 35 багийн, нийт 44 багийн 352 харваач цэц мэргэнээ сорилоо.

ТӨВ телевизийн нэрэмжит 3х3 сагсан бөмбөгийн өсвөр үеийн анхдугаар тэмцээнийг 2023.04.11-ын өдөр ТӨВ телевизтэй хамтран зохион байгуулж 11 сумын эрэгтэй 25 баг, эмэгтэй 10 баг, нийт 35 багийн эрэгтэй 100, эмэгтэй 40 нийт 140 тамирчин оролцлоо.

Аймгийн цагдаагийн газрын ажилтан албан хаагчдын дунд Хүчний 3 төрөлтийн тэмцээнийг зохион байгуулж 23 тамирчин оролцлоо.

Масристингийн аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023.04.15-16-ны өдрүүдэд Баянчандмань суманд зохион байгуулж 124 тамирчин 16 жинд 64 багц медалийн төлөө өрсөлдөж аваргуудаа шалгарууллаа.

Монгол Улсын арслан, Анагаах ухааны доктор, профессор, Чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер П.Давгасүрэнгийн нэрэмжит бөхийн чөлөөт барилдааны өсвөр үе, залуучуудын “Олон хотын тэмцээн”-ийг 2023.04.14-16 ны өдрүүдэд Батсүмбэр суманд зохион байгуулж ОХУ-ын Буриад, БНХАУ-ын Өвөр Монголын болон 31 байгууллагын 650 тамирчид оролцож тэмцээний нээлтийн ажиллагаанд УИХ-ын гишүүн Н.Энхболд, УИХ-ын гишүүн Олимп, нийтийн биеийн тамир, спортын сайд Б.Бат-Эрдэнэ, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Ц.Жамбалсүрэн нар болон бусад албаны төлөөлөл оролцлоо.Тэмцээний үеэр МУ-ын арслан, Анагаах ухааны доктор, профессор, Чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер П.Давгасүрэнгийн хөшөөний шав тавих ёслол зохион байгуулагдлаа.

Төв аймгийн Залуучуудын холбооны нэрэмжит Төв нутгийн залуучуудын спортын бага наадам 2023.04.15-16-ны өдрүүдэд Зуунмод суманд спортын 3 төрлөөр зохион байгуулагдан 61 багийн 572 тамирчин оролцож хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Төв аймгийн түүхт 100 жилийн ойн нэрэмжит 2023 оны өсвөр үеийн Монгол улсын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн 2023.04.24-27- ны өдрүүдэд Зуунмод суманд 16 аймаг 34 клуб, дүүргийн 620 гаруй хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдөж, шилдгүүдээ тодрууллаа.

Төв аймгийн түүхт 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулж буй олимпын таеквондогийн олон хотын нээлттэй тэмцээн 2023.04.28-30- ны өдрүүдэд Зуунмод суманд 4 насны төрлөөр аймаг, клуб, дүүргийн 41 багийн 1175 гаруй тамирчид хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдлөө.

#### **Оролцсон уралдаан тэмцээн**

2023 оны 4-р сарын 20-23-нд Дархан-уул аймагт Жүдо бөхийн залуучуудын 2023 оны улсын аварга шалгаруулах Төв аймгаас 9 тамирчин оролцож 2 мөнгө, 5 хүрэл медаль хүртлээ.

Орхон аймагт зохион байгуулагдсан дугуйн нээлттэй тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 3 алт, 1 мөнгө, 3 хүрэл медаль хүртлээ.

2023 оны Самбо бөхийн улсын аварга шалгаруулах тэмцээнээс 8 алт, 3 мөнгө, 2 хүрэл нийт 13 медаль хүртэж багийн дүнгээр Төв аймаг тэргүүллээ.

2023 оны хэрэглэлтэй /equipped/ пауэрлифтингийн 17 дахь удаагийн улсын аварга шалгаруулах тэмцээн Орхон аймагт 2023.04.-15-16-нд зохион байгуулагдан манай баг тамирчид 7 алт 4 мөнгө 6 хүрэл нийт 17 медаль хүртлээ.

Засмал дугуйн улирлын нээлттэй тэмцээнд өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 2 мөнгө, 1 хүрэл медаль хүртлээ

2023 оны 04-р сард биеийн тамир спортын газар улсын аварга шалгаруулах тэмцээнийг 4 төрлөөр, аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг спортын 6 төрлөөр, нийтийг хамарсан уралдаан тэмцээнүүдийг зохион явуулж 5715 иргэнийг хамруулснаас 2314 эмэгтэй, улс, бүсийн аварга шалгаруулах 6 тэмцээнд амжилттай оролцож 15 алт, 13 мөнгө, 19 хүрэл нийт 47 медаль хүртлээ.

#### **НАЙМ: ЦЭРГИЙН ШТАБЫН ХҮРЭЭНД:**

Аймгийн Засаг даргын 2023 оны А/201 дүгээр захирамж, ЗДТГ-ын Цэргийн штабын даргын 14 дүгээр албан даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Дайчилгаа, хүний нөөцийн тасаг, сумын Засаг дарга, ЗДТГ-ын дарга, багийн Засаг дарга нартай хамтран 2023 оны 04 дүгээр сарын 3–7-ны өдрүүдэд батлагдсан, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Алтанбулаг, Архуст, Баян, Баяндэлгэр, Баянцагаан, Баян-Өнжүүл, Зуунмод, Эрдэнэ сумдуудын Дайчилгааны нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн, Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн томилгоот бүрэлдэхүүнд сургалт зохион байгууллаа.

Хугацаат цэргийн алба хаах насны иргэдийн эрүүл мэндийн асуудлаар Цэргийн төв эмнэлгийн эмч нарын комиссын бүрэлдэхүүн, цэрэг татлагын товчооны эмч нартай сургалт зохион байгуулж, Цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй иргэдэд эрүүл мэндийн үзлэгийг 2023 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгуулж явуулсан.

Аймгийн 2023 оны I ээлжийн цэрэг татлагын ажлыг 11 суманд Засаг даргын 2023 оны А/255 дугаар захирамжаар томилогдсон бүрэлдэхүүн 04 дүгээр сарын 18-28 ны өдрүүдэд эрүүл мэндийн үзлэг явуулж цэрэг татлага зохион байгуулсан.

Цагдаагийн албаны болон Дотоодын цэргийн Сүхбаатарын одонт, Байлдааны гавьяаны одон болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, цагдаагийн тангараг давтах ёслол хүндэтгэлийн арга хэмжээ Төв аймгийн Зуунмод сумын “Мөнх-Алдар”-ын талбайд 04-р сарын 17-ны өдөр зохион байгуулагдлаа.

**ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**